



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/31

Аргатай

Газар эзэмших эрхийг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтууд, Газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Тус сумын Аргатай 3 дугаар багийн нутаг дэвсгэрт Дөш 5-506 тоот хаягт байршилтай 1500м.кв (0.15 га) ШТС зориулалттай газрын эзэмшигч (2075261) регистрийн дугаартай Ник ХХК-ний 1500 м.кв (0.15га) газрыг (2880202) регистрийн дугаартай Оройт ХХК-нд зориулалтаар нь шилжүүлж 6 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг газрын даамал (Т.Шуухааз)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/15 дугаар захирамж, газар эзэмших эрхийн 000005027 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЗОЛЗАЯА

482301076